



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 21 өдөр

Дугаар A/93

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 35.2 заалт болон Төвийн хөгжил хөтөлбөр 2.2 дахь заалтыг хэрэгжүүлэх, Зоонозын халдварт өвчний шалтгаант үйл явдал (мэрэгч амьтад, дамжуулагч) бүхий дуудлагад шуурхай үйлчлэх, хүн амьтг халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах зорилгоор Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2020 оны 07 сарын 20-ны өдрийн удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Зоонозын халдварт өвчний сэжигтэй амьтны дуудлагад үйлчлэх” шинэчлэгдсэн журмыг I, Амьтны дуудлагын бэлэн байдлын үед шаардлагатай эд зүйлсийн жагсаалтыг II, Амьтны дуудлагад үйлчилсэн тэмдэглэлийн маягтыг III, Дуудлагаар ирсэн амьтад, тэдгээрийн сорьцыг устгасан бүртгэлийг IV хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү журмыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын алба /Д.Отгонбаяр/, Нэгдсэн лабораторийн алба /Д.Ганболд/, Аймаг нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвүүдийн дараг нарт тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын алба /У.Нармандах/, дэд захирал /Б.Амгаланбаяр/ нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ЗӨСҮТ-ийн захирлын 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн A/65 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий
захирлын 2020 оны 12 дугаар сарын 27-ны
өдрийн 1193 дугаар тушаалын I хавсралт

Зоонозын халдварт өвчний холбогдолтой амьтны дуудлагад үйлчлэх журам

Нэг. Нийтлэг зүйл:

2020 он

Энэхүү журмын зорилго нь шалтгаан тодорхойгүй үхсэн, ахуйн орчинд шинээр нэвтэрсэн амьтны дуудлагад үйлчлэх болон зоонозын холбогдолтой өвчний халдвар тархах эрсдэлийг бууруулах, таслан зогсоох зэрэг үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1. Амьтны дуудлагад үйлчлэх гэдэг нь: Хүн ам төвлөрсөн хот суурин, хөдөө орон нутагт мэрэгч амьтад, үе хөлтөн, тэдгээрийн эд эрхтэн, сэг зэм, түүхий эдэд байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний тархвар судлалын холбогдлыг мэдээллийн дагуу тогтох, халдвар тархаах эрсдэлийг бууруулах, таслан зогсоох үйл ажиллагааг хэлнэ.
2. Зоонозын өвчний холбогдолтой амьтны дуудлагад Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/160, тушаал “Тарваган тахал өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний заавар”, А/161 дүгээр тушаал “Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн заавар”-ыг тус тус баримтлан ажиллана.
3. Аймаг, нийслэл дэх ЗӨСТ-д хийгдсэн амьтны дуудлагын лабораторийн шинжилгээний зэрэг хариу (зэрэг сорьц, материал болон есгевөр илэрсэн тохиолдол)-ны дунг ЗӨСҮТ-ийн лавлагаа лабораторит баталгаажуулна.

Хоёр: Үйлчлэх хүрээ

- 2.1. Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд –ЗӨСҮТ, орон нутагт-ЗӨСТ-д үйлчлэнэ.
- 2.2. Зоонозын өвчин судлалын байгууллагууд нь дараах шалгуурын дагуу дуудлагыг хүлээн авч үйлчилнэ: **Үүнд:**
 - 2.2.1. Тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчний холбогдол бүхий мэрэгч, туулай хэлбэртэн: (тарвага, зурам, отоно, хулгана, харх, огдой, туулай гэх мэт мэрэгчид)
 - 2.2.2. Галзуу өвчний холбогдол бүхий зарим үхсэн араатан амьтад: (үнэг, хярс, дорго, өмхий хүрэн, гар далавчтан)
 - 2.2.3 Хачиг, шумуулаар дамжих халдварын холбогдол бүхий үе хөлтөн (бүүрэг, хачиг)
 - 2.2.4 Шувууны томуу өвчний холбогдол бүхий нүүдлийн шувууд: (галуу, нугас, хиазатын овгийн шувууд) зэрэг шалтгаан тодорхойгүй үхсэн болон төрөл, зүйл нь тодорхойгүй, халдварт өвчний сэжигтэйамьтан илэрсэн мэдээллийн дагуу дуудлагад хүлээн авна.
- 2.3. Төрөл, зүйл нь тодорхойгүй үхсэн болон амьд амьтдыг дуудлагын биологич дуудлага ёгсөн иргэнээс утсаар холбогдох мэдээллийг авч очих эсэхийг шийдвэрлэнэ. Үүнд: тоо ширхэг, байршил, амьтны гадаад шинж төрх, нөхцөл байдал гм
- 2.4. Гэрийн тэжээвэр мал, амьтны дуудлага (нохой, муур, таван хошуу мал)-ыг мал эмнэлгийн байгууллагад шилжүүлнэ.
- 2.5. Нийслэл орчмын зусландаа тархсан мэрэгч амьтаны хувьд тухайн амьтан нь үхээгүй, ямар нэг сэжигтэй шинж тэмдэг илэрээгүй тохиолдолд Нийслэлийн БОГ-тай холбогдож хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж өгнө.

Гурав: Амьтны дуудлага хүлээн авах, мэдээлэх

- 3.1. Дуудлага хяналтын жижүүр бага эмч нь амьтны дуудлагыг хүлээн авч мэдээ мэдээллийг баталгаажуулах бөгөөд дуудлага өгсөн хувь хүн, байгууллагад нь халдвартархах, сорьц материал алдагдахаас сэргийлэх тухай заавар зөвлөгөөг өгч, "Амьтны дуудлагын холбогдох бүртгэлд тэмдэглэн Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны даргад мэдээлэн баг бүрэлдэхүүнийг шуурхай бурдуулнэ.
- 3.2. Дуудлагад үйлчлэх баг бүрэлдэхүүн нь ажлын цагаар (08^{30} - 15^{30} цаг) хот дотор 1 цагийн дотор, ажлын бус цагаар 2 цагийн дотор, харин аймаг, орон нутагт зайнаас хамаарч аль болох шуурхай үйлчлэн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.3. Дуудлагад үйлчлэх баг бүрэлдэхүүн нь дуудлагын хөдөлгөөнт баг, лабораторийн шинжилгээний баг гэсэн 2 хэсгээс бүрднэ.
- 3.4. Дуудлагын хөдөлгөөнт баг бүрэлдэхүүнийг амьтан судлагч, шимэгч судлагч удирдах ба шаардлагатай тохиолдолд тархвар судлагч удирдана. Дуудлагын хөдөлгөөнт баг бүрэлдэхүүнд амьтан судлал, шимэгч судлалын лаборант, ариутгагч, дуудлагын жолооч ажиллах ба байгууллагын захирал, даргын шийдвэрээр нэмэлтээр лабораторийн баг бүрэлдэхүүн ажиллуулна.
- 3.5. Лабораторийн шинжилгээний баг бүрэлдэхүүн (вирус, нян судлагч эмч, генетикч, лаборант, бэлдмэлч, ариутгагч) нь сорьц материалд зоонозын халдвартархийн шинжилгээг хийж материал хүлээн авснаас хойш ийлдэс судлал, вирус, нян судлал, молекул биологийн баталгаат шинжилгээний дүн гарах хүртэлх үйл ажиллагааг хариуцна.
- 3.6. Тухайн сарын дуудлагын багийн ахлагч тархвар судлагч эмч нь лабораторийн баталгаат шинжилгээний хариуг үндэслэн дүгнэлт гаргаж, дуудлага өгсөн хувь хүн, албан байгууллагад албан тоот болон утсаар эргэн мэдээлнэ.

Дөрөв: Дуудлагын дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 4.1. Тухайн сарын томилогдсон биологич, лаборант, ариутгагч, жолооч нар амьтны дуудлагын бэлэн байдлыг хангаж үйлчлэх ба шаардлагатай тохиолдолд (хүн амын дунд тархвар судлалын эрсдэл үүсч болзошгүй тохиолдол) тархвар судлагч эмч ажиллана.
- 4.2. Лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн шаардлагатай тохиолдолд дуудлагын багийн тархвар судлагч эмч, биологич, нян судлагч эмч нар тархвар судлалын холбогдол, эрсдэлийг үнэлж, хариу арга хэмжээг зохион байгуулна..
- 4.3. Амьтны дуудлагад үйлчлэхдээ нэг удаагын хамгаалах өмсгөл, хувцас хэрэгсэл хэрэглэх ба нүдний шил хэрэглэхгүй байж болно.
- 4.4. Ажлын бус цагаар ирсэн амьтны дуудлагын сорьц материалыг яаралтай шинжлэх асуудлыг дуудлагад үйлчилсэн биологч нь үйл ажиллагааны нөхцөл байдал, тархвар судлалын холбогдлыг үндэслэн албаны даргад мэдээлж албаны даргын шийдвэрээр шийдвэрлэнэ.
- 4.5. Ажлын цагаар дуудлагын сорьц материалыг амь сорьцын лабораторит хүлээлгэн өгч шинжлүүлэх ба ажлын бус цагаар бол дуудлага хяналтын жижүүр эмчийн хяналтад сорьц түр хадгалах хөргөгчид шинжилгээ хийх хүртэл байлгана.
- 4.6. Үе хөлтөн амьтан (хачиг, шумуул, жоом, цох)-ы дуудлага ирсэн болон хувь хүн өөрсдөө авч ирсэн тохиолдолд тухайн амьтны төрөл, зүйл, өвчний холбогдлыг тогтоон дуудлага өгсөн иргэн, албан байгууллагад эргэн мэдээлнэ.
- 4.7. Дуудлагаар ирсэн үе хөлтөн (хачиг, шумуул)-ний материалд лабораторийн шинжилгээ хийх асуудлыг тухайн сарын дуудлагын тархвар судлагч эмч шийдвэрлэнэ.

4.8. Амьд амьтны дуудлагад үйлчлэх тохиолдолд дараах зүйлийг баримтлан ажиллана:

4.8.1 Жижиг мэрэгч (хулгана, зурам, гэх мэт) амьтныг урт хямсаа, хавчаараар багалзуур хэсэгт хавчиж үхүүлсний дараа тээвэрлэнэ.

4.8.2. Шавж, шумуул зэрэг үе хөлтөн амьтдыг өдрийн цагт тор, сачок, шөнийн цагт гэрлээр баригч зэрэг тухайн нөхцөлд тохирсон багаж ашиглан барьж халдвэр хамгааллын дэглэмийн зааварын дагуу тээвэрлэнэ.

4.8.3. Нийслэл орчмын зусландаа тархсан мэрэгч амьтны хувьд тухайн амьтан нь үхээгүй, ямар нэг сэжигтэй шинж тэмдэг илэрээгүй тохиолдолд Нийслэлийн БОГ-тай холбогдож шийдвэрлэх талаар зөвлөмж өгнө.

Хэрэв амьд тарвага болон мэрэгч амьтны дуудлагад үйлчлэх тохиолдолд тухайн амьтныг сайтар ажиглах ба хөдөлгөөний идэвх суларсан, арьс үс нь шархалсан, хачиг, бүүрэгт баригдсан, бэртэж гэмтсэн тохиолдолд амьтан баригч дэгээ, тор ашиглан барьж зөөвөрлөх хайрцагт хийж байгууллагын хашаанд авчирал (зөвшөөрөгдсөн цэгт) амьтныг зовоолгүй хурдан үхүүлнэ.

4.10. Эргүүлэн байгальд нь тавих тохиолдолд:

4.10.1. Тухайн газар нутаг нь тарваган тахлын голомтод бусд тэмдэглэгдээгүй байх

4.10.2. Сүүлийн 3 жилийн хугацаанд тарваган тахлын байгалийн голомтын шинжилгээнд хамрагдаж, халдвартай материал илэрээгүй.

4.10.3. Сүүлийн жилүүдэд тухайн нутагт амьтан шинээр нутагшуулсан эсэх

4.10.4. Гадаад шинж чанар хэвийн, тарга тэвээрэг сайн, бэртэл гэмтэлгүй байх

4.10.5. Хөдөлгөөний идэвх хэвийн зэрэг шинж тэмдэг илэрсэн тохиолдолд фото зураг авч баримтжуулж, зориулалтын багажаар барьж байгальд нь ойролцоо нүхэнд буцааж тавина.

4.11.Дуудлагаар авчирсан амьтанд биеийн хэмжилт, самналтыг хийж дагалдах хуудсын хамт лабораторийн нян судлагч эмчид хүлээлгэн өгнө. Харин амьтнаас цуглуулсан гадны шимэгчийг "Шимэгч судлалын лаборатори"-д төрөл, зүйлийг тодорхойлон, лабораторт өгч шинжилүүлнэ.

4.12.Лабораторийн шинжилгээнд хүлээн авсан сорыц материалын тархвар судлалын холбогдлыг үндэслэн зоонозын халдварт өвчний үүсгэгчийг илрүүлэх, тодорхойлох шинжилгээ хийнэ. Шинжилгээний эхний шатанд хурдан, найдвартай, мэдрэг болон өвөрмөц чанар өндөртэй ийлдэс судлалын аргууд ашиглах ба шинжилгээний дүн зэрэг тохиолдолд өсгөвөрлөх, дүйн тодорхойлох сорилууд болон полимеразын гинжин урвалаар баталгаажуулна.

4.13.Дуудлагаар авчирсан сорыц материал нь лабораторийн шинжилгээний шаардлага хангахгүй (тухайлбал: өмхийрсэн, муудсан, шинжилгээнд түгээмэл авдаггүй эд эрхтэн, илжирч хуучирсан арьс, үс, ноос гэх мэт) тохиолдолд тухайн сарын дуудлагын биологич, тархвар судлагч эмчид мэдээлэн, дүгнэлт гарган устгүүлж тэмдэглэл хөтлөн, зургаар баримтжуулах ба амьтны дуудлагын бүртгэлд тэмдэглэнэ. Шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагын төлөөлөл болон хувь хүнийг байлцуулан устгаж болно.

4.14.Мэрэгч амьтан болон түүхий эд тээвэрлэсэн тээврийн хэрэгслэл болон түр зөөвөрлөсөн сав, орчныг ДТ-0,02% болон 0,03%-ийн жавелоны уусмалаар шүршиж халдвартгүйтгэл хийнэ.

4.15.Улирлын онцлогоос (7-10 сард) хамаарч нэг зэрэг 2 буюу түүнээс дээш дуудлага ирсэн тохиолдолд нөхцөл байдлаас шалтгаалж, дараа сарын хуваарьтай дуудлагын баг үйлчлэх ба НЭМТШУА-ны даргын удирдлага доор ажиллана.

- 4.16. Батлагдсан жагсаалтын дагуу дуудлагын бэлэн байдлын 2 хайрцагт байх эд зүйлсийг /хавсралт 1/ бэлтгэх, нөхөн хангалтыг биологич нь тасгийн бага эмчтэй хамтран хариуцаж, хэрэгжүүлэх ба дараагийн хуваарын биологичид хүлээлгэн өгнө.
- 4.17. Тухайн сарын дуудлагын багийн гишүүд нь хүндэтгэх шалтгааны улмаас ажиллах боломжгүй нөхцөлд багийн ахлагч (тархвар судлагч эмч)-аар дамжуулан НЭМТШУА-ны даргад урьдчилан мэдэгдэн зохицуулалт хийгдсэн байна.
- 4.18. Лабораторийн шинжилгээний дүн, тархвар судлалын эрсдэлийг харгалzan мэргэжлийн алба, хариуцсаннэгжийн мэргэжилтнүүд хамтарсан хяналт, үнэлгээ хийж, халдварт эсэргүүцэх арга хэмжээг хэрэгжүүлэн холбогдох байгууллагад зөвлөмж бичиж хүргүүлнэ.
- 4.19. "Мэрэгч амьтны дуудлагад үйлчилсэн тэмдэглэл"-ийг (хавсралт-2) дуудлага өгсөн төрийн албан хаагч болон хувь иргэнд 1 хувь үйлдэж өгнө.

Тав: Дуудлагын багийн бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь:

- Тархвар судлагч эмч
- Эмнэл зүйч эмч
- Нян судлагч
- Амьтан, шимэгч судлагч, шимэгч судлалын лаборант
- Нян судлалын лаборант
- Ариутгагч
- Бэлтгэмэлч
- Жолооч
- Шаардлагатай тохиолдолд Генетикч, Зоо-лаборант дотоод хуваарийн дагуу үйлчилнэ

5.1. Тархвар судлагч эмчийн үүрэг

- 5.1.1. Тархвар судлагч эмч нь дуудлагын багийн ахлагч байх ба дуудлагад шуурхай, цаг алдалгүй үйлчилэх багийн зохион байгуулалтын асуудлыг хариуцна.
- 5.1.2. Багийн бүрэлдэхүүний Эрүүл мэндийн сайдын 2017 оны 261 дүгээр тушаал "Зоонозын өвчний үед баримтлах халдварт хамгаалал, био-аюулгүй ажиллагааны дэглэмийн заавар"-ийн хэрэгжилтэд хяналт тавих ба шаардлагатай тохиолдолд дуудлагад үйлчилнэ.
- 5.1.3. Сарын дуудлагад үйлчилсэн ажлын талаар алба, тасгийн эрхлэгч нарт мэдээлэл өгч холбогдох асуудлаар Төвийн удирдлагыг цаг алдалгүй мэдээлэлээр хангана.
- 5.1.4. Хууль тогтоомжийн дагуу Цагдаагийн ерөнхий газар, улсын мөрдөн байцаах газартай хамтран ажиллаж ЗӨСҮТ-ийг төлөөлөн холбогдох мэдээллийг солилцон шийдвэрийг гаргана.
- 5.1.5. Дуудлагаар ирсэн сэжигтэй материалын шинжилгээний дүнд тархвар зүйн судалгаа хийж, баталгаат хариуг дуудлага өгсөн хувь хүн, албан байгууллагад эргэн мэдээлж, цаашид сэрэмжлүүлэх арга хэмжээний талаар зааварчилгаа, зөвлөмжийн хамт хүргүүлнэ..

5.2. Эмнэл зүйч эмчийн үүрэг

- 5.2.1. Дуудлагын тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, зоонозын халдварт шалтгаант үйл явдал, дэгдэлтийн үед орон нутгийн мэргэжлийн салбар, бусад эрүүл мэндийн байгууллага, иргэдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэх, дуудлагын багийн эрүүл мэндийг тогтмол хянаж, зөвлөгөө өгөх.
- 5.2.2. Дуудлагад хэрэглэгдэх хамгаалах хувцас, эм, багаж хэрэгслүүдийн бэлэн байдалд хяналт тавих ба халдварт эрсдэлтэй эд зүйлстэй харьцсан хүмүүсийг эрүүл мэндийн

үзлэгт хамруулах, шаардлагатай тохиолдолд ХӨСҮТ-д хэвтүүлэх, оношийг тодруулах асуудлыг хариуцан ажиллана.

5.3. Нян судлагч эмчийн үүрэг Лабораторийн эмч

- 5.3.1. Дуудлагаар ирсэн сэжигтэй материалыг лабораторийн шинжилгээнд хамруулах, баталгаат шинжилгээний хариу гаргах, үйл ажиллагааг хариуцан ажиллана.
- 5.3.2. Дуудлагад зайлшгүй шаардлагатай эм, ариутгалын бодис, оношлуур болон лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг жагсаалтын дагуу бэлэн байдлыг хангах ба шинжилгээний урьдчилсан, сэжигтэй болон баталгаат хариуг дуудлага хяналтын эмчид мэдээлж, бүртгэлд тэмдэглэнэ.
- 5.3.3. Урьдчилсан шинжилгээний хариуг лабораторит шинжилгээ эхэлснээс хойш 8-12 цагийн дотор, мэдээлэх баталгаат шинжилгээний хариуг 72 цагийн дотор гарган тасгийн эрхлэгчид мэдэгдсэний үндсэн дээр тархвар судлагч эмчид мэдээлнэ.

5.4. Амьтан, шимэгч судлагч, шимэгч судлалын лаборант нарын үүрэг

- 5.4.1. Дуудлагад үйлчилж халдвартын сэжигтэй материалыг очиж авах ба шаардлагатай багаж хэрэгсэл бэлэн байдалд хяналт тавьж ажиллана.
- 5.4.2. Биологич нь хураагдсан материалыг хүлээн авахдаа тухайн сэжигтэй материалын тоо ширхэг, төрөл, зүйл, (боломжтой тохиолдолд хүйсийг тогтоох), тээвэрлэж байгаа хүний нэр хаягийг дуудлага өгсөн албан тушаалтан, хувь хүнээс авч, тэмдэглэл хөтөлж (хавсралт-3) гэрэл зургаар баталгаажуулна.
- 5.4.3. Хэрэв өөр төрлийн амьтад (мэрэгч болон сарьсан далавчтан, үе хөлтнөөс бусад амьтан) байгаа тохиолдолд дуудлагын багийн ахлагч тархвар судлагч эмч зааврыг үндэслэл болгон ажиллана.
- 5.4.4. Дуудлагаар ирсэн сорьц, материалыг ЗӨСҮТ-ийн халдварт хийх өрөөнд халдварт хамгааллын дэглэмийг баримтлан самналт хийж гадны шимэгчийг түүх, биологийн хэмжилт, нас, хүйс, зүйлийн бурдэл, агналтын байдлыг тогтоож, гэрэл зургаар баталгаажуулна.
- 5.4.5. Цуглуулсан гадны шимэгчийг шимэгч судлалын лабораторит батлагдсан журмын дагуу зүйлийн бурдэл, тоо ширхэгийг тогтоон дагалдах бичгийн хамт нян судлалын лабораторит шилжүүлэн шинжилгээнд хамруулна.
- 5.4.6. Тухайн сарын дуудлагад үйлчилсэн ажлын илтгэх хуудсыг зардлын тооцоо, нэгтгэсэн тоон мэдээн хамтран боловсруулж, албаны даргад мэдээлнэ.

5.5. Нян судлалын лаборантын үүрэг

- 5.5.1. Лабораторид шаардлагатай оношлуур, эм урвалж, тэжээлт орчин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд аж ахуйн зүйлийг жагсаалтын дагуу бэлэн болгох ажлыг хариуцан ажиллана.
- 5.5.2. Дуудлагаар ирсэн материал (мэрэгч)-аас шинжилгээний сорьц бэлтгэх, шинжлэх ажлуудыг нян судлагч эмчийн хяналтан дор гүйцэтгэнэ.
- 5.5.3. Лабораторид хийгдэх байнгын халдвартгүйтгэлд хяналт тавьж, лабораторийн анхан шатны бүртгэлийг хөтөлнө.

5.6. Ариутгагч, бэлдмэлчийн үүрэг

- 5.6.1. Дуудлагад үйлчилж, сэжигтэй материалы тээвэрлэсэн тээврийн хэрэгслэл, хадгалагдаж байсан ойр орчмын талбайг заавар, журмын дагуу халдвартгүйтгэх ба шинжилгээнд хэрэглэх шилэн эдлэл, тэжээлт орчин, бусад материалыг ариутгалд оруулж, тэмдэглэл хөтөлнө.

- 5.6.2. Ариутгал, халдвартгүйжүүлэлтэд хэрэглэх бодис, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хувцас, эд, аж ахуйн хэрэгслийг захиалах ба жагсаалтын дагуу бэлэн болгоно.
- 5.6.3. Халдвартын сэжигтэй материалын сорьц авч дууссаны дараа устгалд оруулахдаа халвар судлагч эмчийн хяналтад, халдвараас сэргийлэх хяналтын багийн гишүүнийг байлцуулан устгаж, хууль зүйн үндэслэлтэй, устгалын явцыг дэлгэрэнгүй тусгаж, гэрэл зургаар баталгаажуулан "Устгалын бүртгэл"-д тэмдэглэнэ.
- 5.6.4. Шинжилгээнд хэрэглэгдсэн лабораторийн багаж хэрэгсэл, зөвлөн эдлэл, шилэн эдлэл, хамгаалах өмсгөлийг халдвартгүйжүүлэх болон ариутгалд хүлээлгэн өгнө.
- 5.6.5. Дуудлагад үйлчилсэн тээврийн хэрэгслийг халдвартгүйжүүлнэ

5.7. Жолоочийн үүрэг


- 5.7.1. Дуудлагад үйлчлэх тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг хангана.
- 5.7.2. Дуудлагын багийн тархвар судлагч эмч болон биологичийн шууд удирдлагад ажиллаж, явсан маршрут километрийн тооцоог гаргана.
- 5.7.3. Дуудлага хүлээн авснаас хойш дуудлага өгсөн газарт ажлын цагаар (08^{30} - 15^{30} цаг) хот дотор 1-2 цагт, ажлын бус цагаар (15^{30} - 08^{30} цаг) 2-3 цагийн дотор багийн гишүүдийг хүргэнэ.
- 5.7.4. Дуудлагад үйлчилсийй дараа тээврийн хэрэгсэлд байнгын ба эцсийн халдвартгүйжүүлэлт хийлгүүлэн бүртгэлжүүлсэн байна.

Зоонозын өвчин судалын үндэсний төвийн ерөнхий
захирлын 2020 оны 12 дугаар сарын 21-ны
өдрийн 11:30 дугаар тушаалын II хавсралт

Амьтны дуудлагын бэлэн байдлын хайрцагт байх эд зүйлсийн жагсаалт

№	Хэрэглэгдэх зүйлс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	
			Байнгын хайрцагт	Явуулын хайрцагт
1	Нэг удаагийн өмсгөл (нимгэн)	ш	10	3
2	Нэг удаагийн өмсгөл (зузаан)	ш	5	2
3	Усны гутал	ш	2	1
4	GPS (шаардлагатай үед)	ш	1	1
5	Нимгэн бээлий	хос	50	10
6	Зузаан бээлий	ш	2	1
7	Амны хаалт	ш	20	5
8	Пиджам	хос	2	1
9	Тарваганы хайч	ш	1	1
10	Хогны уут (шар)	ш	100	10
11	Тарваганы уут	ш	10	5
12	Жижиг мэрэгчийн уут	ш	10	5
13	Зузаан плёнкон уут	ш	2	1
14	Гулигдасны уут	ш	10	10
15	Бикс (жижиг, дунд)	ш	1	-
16	Зөөлөн хямсаа	ш	1	-
17	Корнцанг (том)	ш	2	1
18	Хавх	ш	3	3
19	Занга	ш	5	5
20	Хуруу шил	ш	5	-
21	Автомакс	ш	1	1
22	Хуруу лент	ш	10	10
24	Гарын алчуур	ш	1	1
25	Денатурат спирт	л	0,5	0,2
26	Этилийн спирт	л	0,5	0,2
27	Иод	мл	20	20
29	Жавелион (ДП-2Т)	ф	1	30 ш
30	Санитол	л	1	200 гр
31	Тамедин	ш	5	2
32	Гар арчих бөмбөлөг	ш	20	20
33	Амътан барих тор (дэгээ)	ш	1	1
34	Амътан барих дэгээ, тор, бугуйл	ш	1-1	1

Зоонозын явчин судлалын ундэсний төвийн ерөнхий
захирлын 2020 оны 12 дугаар сарын 21-ны
өдрийн 1/23 дугаар тушаалын III хавсралт



Дуудлагад үйлчилсэн тэмдэглэл

Дугаар №

Дуудлага хүлээн авсан хугацаа: он.....сар.....өдөр цагминут

Дуудлага хүлээн авсан хаяг:

Дуудлагын мэдээлсэн: (албан тушаалтан, иргэний нэр):

Овог: Нэр:

Албан тушаал:

Холбогдох утас:

Сорьц материалын гарал үүсэл /аймаг, сум, газар/

Сорьц материалын нэр, төрөл:

Нийт тоо хэмжээ:

Дуудлага өгсөн хүний гарын үсэг:

Сорьц хүлээн авсан хүний гарын үсэг, албан тушаал:

..... он.....сар.....өдөр

Дуудлагад үйлчилсэн тэмдэглэл

Дугаар №

Дуудлага хүлээн авсан хугацаа: он.....сар.....өдөр цагминут

Дуудлага хүлээн авсан хаяг:

Дуудлагын мэдээлсэн: (албан тушаалтан, иргэний нэр):

Овог: Нэр

Албан тушаал:

Холбогдох утас:

Сорьц материалын гарал үүсэл /аймаг, сум, газар/

Сорьц материалын нэр, төрөл:

Нийт тоо хэмжээ:

Дуудлага өгсөн хүний гарын үсэг:

Сорьц хүлээн авсан хүний гарын үсэг, албан тушаал:

..... он.....сар.....өдөр

Зоонозын евчин судлалын үндэсний төвийн захильтын 2020 оны 12 сарын 17.эдрийн дугаар тушаалын IV дүүзээр хавсралт

Дуудлагаар ирсэн амьтад, тэдгээрийг сорьцыг үстгасан буурыгэл